



ДОРНОГОВЬ АЙМАГ
ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/146

Сэнж

Газар эзэмшүүлэх дуудлагын худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай", Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сумын "Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 2025 оны 7/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын "Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө"-д тусгагдсан газар эзэмшүүлэх дуудлагын худалдааг зохион байгуулсугай.
2. Дуудлагын худалдаагаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмшүүлэх дуудлагын худалдааг 2026 оны 06 дугаар сарын 18-ний өдөр зохих журмын дагуу танхимын хэлбэрээр зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Г.Одбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАТ-АМГАЛАН

D disk/ Zahiramj

Засаг даргын 2016 оны 04 дугаар
сарын 16 ны өдрийн 11/16 дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ,
ЗОРИУЛАЛТ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ,
ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Газрын байршил	Газрын зориулалт	Талбайн хэмжээ (га)	Төлөвлөлт ийн нэгж талбарын дугаар	Дуудлага худалдааны анхны үнэ (төг)	Дэнчингийн хэмжээ (төг)
1	1-р баг Зээгийн хөтөл	Мод үржүүлгийн газар	5.2267	4948830	6 272 040	627 204
2	1-р баг Хүрэн цавын голын хажууд	Мод үржүүлгийн газар	1.4120	4948831	1 694 400	169 440
3	1-р баг Хүрэн цавын голын хажууд	Мод үржүүлгийн газар	1.5881	4948832	1 905 720	190 572

--oOo--